



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/44

Эмээлтолгой

Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс
урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг дахиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, "Мал, амьтны эрүүл мэндийн тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.5, 9.6, 9.7, 9.8, 31 дүгээр зүйлийн 31.48 Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн "Шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай" тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Олон Улсын худалдааны хорио цээрт мал, амьтны гоц халдвар шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх масс дархлаажуулалтыг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл 20 хоногийн хугацаанд чанартай хийж, малчин өрхийн малын эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийж, гүйцэтгэлийг "Мал эмнэлгийн нэгдсэн систем"-д оруулахыг Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.

2.Мал, амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын ажлыг яаралтай зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

3.Дархлаажуулалтын ажилд мал сүргээ бүрэн хамруулж, хашаа хороо, хүн хүчээр хангах, дархлаа тогтох хүртэл 28 хоногийн хугацаанд тухайн малчны хотоос мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг хүнсний зориулалтаар хэрэглэх, зах зээлд гаргаж борлуулах, нөөц бүрдүүлэх, малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдэл хийх, хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжүүд, уяач нарт хориглосугай.

4. Дээрх ажлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр ханган, ажлын явцад байнгын хяналт тавьж, дэмжлэг туслалцаа үзүүлэн ажлын хэрэгжилт, дүн мэдээг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдөрт багтаан аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн улсын байцаагч (С.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т даалгасугай.

ДАРГА



~~Д.МӨНХЖАРГАЛ~~

Сумын Засаг даргын 2020 оны 04 дугаар
сарын 13-ны өдрийн А/Н дүгээр
захирамжийн хавсралт



Ажлын хэсгийн ахлагч: Д.Ганзориг (Засаг даргын орлогч)
Гишүүдэд: Ч.Цэдэвсүрэн (1-р багийн Засаг дарга)
Ж.Должинсүрэн (2-р багийн Засаг дарга)
А.Лхагвадорж (3-р багийн Засаг дарга)
Н.Ганжаргал (4-р багийн Засаг дарга)
Б.Болормаа (Малын их эмч)
С.Нанжид (Малын их эмч)
Т.Уранчимэг (Малын их эмч)
Б.Амгаланбаяр (ИТХ-ын төлөөлөгч)
Б.Гарьдсоном (Биеийн тамирын арга зүйч)
Ц.Ганхуяг (Жолооч)
А.Анхбаяр (ИТХ-ын төлөөлөгч)
Сумын Эрэн хайх аврах салбар
Нарийн бичиг: С.Жаргалсайхан (Мал эмнэлгийн улсын байцаагч)